

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ 2024 ОНЫ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 12 дүгээр сарын 15.

Жаргалант сум

Д/д	Шийдвэрийн нэр огноо, дугаар	Зүйл, заалтын дэс дугаар агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан	Үнэлгээ /хувь/
1	2	3	4	5	6	7
1.2023 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол						
1.1	2023.12.18, Дугаар 04 Сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай	1.Сумын Засаг даргын 2021-2024 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай. 2.Сумын Засаг даргын 2021-2024 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөнд 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнүүдийг нэмж тусган хэрэгжүүлж, төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга /Ц.Бямбажав/-т даалгасугай.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг жилд 2 удаа, 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл хөтөлбөрөөс 2024 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаа. 2024 оны 12 дугаар сарын 25 ны өдрийн хуралдаанаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх асуудлыг хэлэлцүүлэхээр төлөвлөсөн Мөн 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 75 хувийн биелэлттэй дүгнэж хуралдааны			90

			тогтоолоор үүрэг чиглэл өгч ажиллаа. Хасаг жилийн байдлаар үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 3 бүлгийн 171 заалтаас нийгмийн хөгжлийн бодлогын биелэлт 72, орон нутгийн хөгжлийн бодлого хөрөнгө оруулалтын ажлын биелэлт 68, хариуцлагатай төсөв, хяналттай зарцуулалт, сахилга баттай засаглал ажлын биелэлт 85 хувьтай байна.			
1.2	2023.12.18 Дугаар 05 Сумын 2024 оны төсөв батлах тухай	1.Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан сумын 2024 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдагдсанаар баталсугай. 2.Сумын 2024 оны төсвийн эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай. 3.Сумын 2024 оны төсвийн жилд төсвийн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай. 4.Сумын төсвөөс 2024 оны төсвийн жилдтөсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай. 5.Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад олгох орон нутгийн санхүүжилтийн хэмжээг дор дурдсанаар баталсугай. 6.Улсын Их Хурлаас баталсан төсөвтэй холбогдуулан сумын 2024 оны төсвийн тодотголоор төсвийн санхүүжих эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай.	Сумын 2024 оны төсвийг 2023.12.18-ны өдрийн Сумын Иргэдийн төлөөлгчдийн хурлын 05 дугаар тогтоолоор баталсан.Батлагдсан төсвийг хуулийн хугацаа цагалбарын дагуу Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст албан тоотоор хүргүүлэн санхүүжилт зарцуулалтын эрх Freebalance- системд эрх нээлгэн,сар бүрийн батлагдсан хуваарийн дагуу ЗЭБ-1 маягтаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталгаажуулсанаар сар бүрийн 20-ны дотор санхүүжилтийг бүрэн олгосон.Төсвийн зарлага сар бүрийн гүйцэтгэлээр гарч ,өр авлагагүй ажиллаж байна.Тайлант онд 623,362.0 мян. төгрөгөөр үүнээс малын тоо толгойн албан татврыг 48,000.0мян. төгрөгөөр төлөвлөж батлагдсан сарын			80

		1. Суманд олгогдох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 1,271,503.2 мянган төгрөг, 2. Сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 623362.0 мянган төгрөг, үүнээс суманд малын тоо толгойн албан татварыг 48000.0 сая төгрөг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 271887.5 мянган төгрөг, 4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 141,366.4 мянган төгрөг 5. Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 638,466.0 мянган төгрөгөөр тус тус баталсугай. 7.Сумын ерөнхий орлогын дансны 2023 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл давсан орлогыг мянган төгрөгийг тогтоолын нэгдүгээр хавсралтад заасны дагуу зарцуулсугай. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсөвт холбогдуулан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлэтийг хоёрдугаар, Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтыг гуравдугаар, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ажлын жагсаалтыг дөрөвдүгээр, Сум хөгжүүлэх сангийн 2024 оны орлого зарлагын	хуваарийн дагуу орлого бүрэн орсон.Аймгийн санхүү дэмжлэгээс 1,271,503.2 мян.төгрөг,Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс 271,887.5 мянган төгрөг, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 141,366.4 мянган төгрөг,Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 638,466.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж хэрэгжилт сарын хуваарийн дагуу бүрэн 100%санхүүжигдсэн байна. Төсвийн орлогыг сарын орлогын хуваарийн дагуу ,зарлагыг сарын зарлагын хуваарийн дагуу төсвийн тухай хууль, НББ-ын тухай хууль,бусад эрх зүйн шийдвэрийн дагуу зарцуулсан баййна. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 1 ажилд төсвийн тодотголоор хасагдаж эх үүсврийг өөр зайлшгүй ард иргэдийн хүсэлтийн дагуу арын хорооллын эрчим хүчний хүчдлийг сайжруулах хэрэгцээтэй ажилд шилжүүлсэн байна.Давсан орлогоос 103,051.9 мян.төгрөгөөр ,дансны үлдэгдлийг 160,797.5 мян.төгрөгөөр тус тус баталж гүйцэтгэлийг ирсэн санхүүжилт хуваарийн дагуу батлагдсан зардлыг дагуу зарцуулсан.Соёлын төвийн өмнөх оны түлш халаалтын			
--	--	--	---	--	--	--

		төлөвлөгөөг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай. 8.Төсвийн тухай хуульд заасан зарчмын дагуу төсвийг зохистой удирдаж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, үүссэн өр авлагыг барагдуулах, шинээр өр авлага үүсгэхгүй байх, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг нийт төсөв захирагч нарт даалгасугай.	өглөгөөс 65,8102 мян.төгрөгийг барагдуулж шинээр тухайн онд өр авлага үүсгэлгүй ,Төсвийн тухай хууль,НББ-ын тухай хууль, төлбөр тооцооны дүрэм журмыг баримтлан ажиллаж байна.			
1.3	2023.03.29, Дугаар 04 Журам батлах тухай	1.Сумын хэмжээнд хэрэгжүүлэх “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. 2.Журмын хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар малчдад танилцуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-д даалгасугай.	“Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” Сумын бэлчээрийг хамгаалах зорилгоор Харгана багийн малчид Хөнжлийн эхэнд, Цагаан бургас багийн малчид Зөөлөнгийн хяр, Сангийн далайд Тосонгийн малчид Цэцүүхийн амаар зуны отор хийж зусаж байна. Малын бэлчээрийн усан хангамжийг сайжруулж Цэцүүх багийн Өвөр цахир, Зүүн загал, Асгат, Бага булаг, Цагаан бургас багийн . Цэцүүх, Цагаан бургас, хөнжил, багуудад бэлчээр хамгаалах цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгод үлийн цагаан оготно устгал тэмцлийн ажил Цэцүүх, Цагаан бургас багийн 7000 га бэлчээрт үлийн цагаан оготно устгах ажлыг техникийн үр дүн 85.9 % -тай хийж гүйцэтгэсэн.Мөн бэлчээр хамгаалах, Хадлан тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлэхээр ногоон			70

			тэжээл тариалсан. 136 иргэн 136 50.8 га-д тариалах 30 тн үр тараагдсан байна. / 36 иргэн 8,7 га-д 4,2 тн үр тариа байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ургаагүй болно / Хураалт: 42,1 га-с 182 тн 710 кг ургац хурааж авсан. 91,5 га талбайг хөцөөлөн өвөл ,хаврын улиралд бэлчээрт ашиглаж байна. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж 2 булаг шандын эхийг хашиж хамгаалсан.Мөн Цагаан бургас багт шинээр хоёр худгийн цооног гаргасан. Багийн ИНХ-аар бэлчээр ашиглалтын талаар хүмүүст мэдээ мэдээлэл хийв. Мөн багуудын өдөрлөг дээр 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит 8 хуралдааны 04 дүгээр тогтоолоор батлуулж “БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ”-ийг тус сумын бэлчээрийн нөөц, даацад нь тохируулан зохистой ашиглаж байгалийн жамаараа нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглалтыг экологийн чадавхад суурилсан аргачлалаар төлөвлөх, уг төлөвлөгөөний дагуу улирлын хуваарьтайгаар, зүй зохистой ашиглаж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион			
--	--	--	--	--	--	--

			байгуулж гадна сумын мал хужирлах хугацаа, маршрутыг тодорхой танилцуулав.			
1.4	2023.03.29, Дугаар 08 Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай	1.Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн заалт, хэм хэмжээг Төлөөлөгч нарт сурталчлан, ёс зүйн хороог чиг үүргээ чанартай гүйцэтгэхэд удирдлага зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай. 2.Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлж Төлөөлөгчийн сонгуульт үүргийн биелэлтийг жигд хангуулж ажиллахыг Ёс зүйн хорооны дарга, гишүүд, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд үүрэг болгосугай. Ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд үүрэг болгосугай.	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд Ёс зүйн дүрмийг танилцуулан ИТХ-ын дэргэдэх ёс зүйн хорооны үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.			100
1.5	2023.03.29, Дугаар 09	1.Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. – Дарга: Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч – Нарийн бичгийн дарга: Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга – Ерөнхий боловсролын сургуулийн захирал – 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч – 2 дугаар хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч – Соёлын төвийн эрхлэгч – Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч	Хасах			100

	Зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай	– Засаг даргын Тамгын газрын нярав – Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч – Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч – Ерөнхий боловсролын сургуулийн нярав – 1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн нярав – 2 дугаар хүүхдийн цэцэрлэгийн нярав – Эрүүл мэндийн төвийн нярав – Соёлын төвийн нярав 2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.				
1.6	2023.03.29, Дугаар 10, Хамтарсан багийг шинэчлэн байгуулах тухай	1.Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. – Хамтарсан багийн ахлагч: Ц.Бямбажав (Сумын Засаг дарга) – Нарийн бичгийн дарга С.Болоржаргал (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) – Гишүүд: Б.Энхболор (Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан) – Б.Түвшинжаргал (Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан) – А.Алтанцэцэг (Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан) – Б.Алтанбямба (Засаг даргын Тамгын газрын хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн) – Ө.Түвшинсайхан (Засаг даргын Тамгын газрын улсын бүртгэгч)	2024 оныг Хөвсгөл аймгийн хэмжээнд “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан, сумын засаг даргын захирамжаар ажлын хэсгийг байгуулан жилийн ажлын төлөвлөгөөг 5 зорилт 51 арга хэмжээний хүрээнд батлуулан ажиллаж жилийн эцсийн дүнгээр 90 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.Хүүхэд хамгааллын хууль шинэчлэгдсэн 2024 оны 09 дүгээр сарын 01- ны өдрөөс хэрэгжиж хэлсэнтэй холбогдуулан ажил хэрэгтээ тусган ажиллаж байна. Сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг нь “Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих” нэрлэсэн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан			100

		– Ч.Энхбат (Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад) – Л.Санжмаа (1 дүгээр хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч) – Ц.Ариунжаргал (2 дугаар хүүхдийн цэцэрлэгийн багш) – Т.Амар-Атар (5 дугаар багийн иргэн, хүүхдийн элч) 2.Гэр бүлийн талаарх аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэмт хэргийн хохирогч болон хараа хяналтгүй хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалж, тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутагт хамтран зохион байгуулахад “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг чиглүүлэн үр дүнтэй ажиллахыг багийн ахлагч, сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-т, Хамтарсан багийн ажлыг төлөвлөх зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, мэдээ тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Зөвлөлд улирал бүр ирүүлэн, холбогдох газарт тайлагнах, ажлыг Хамтарсан багийн нарийн бичгийн дарга (С.Болоржаргал)-д тус тус даалгасугай.	батлуулж, 2024 оны 04 дүгээр сарын 22 –ны өдөр сумын хэмжээнд нэрлэсэн жилийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Нээлтэнд багш, сурагч, эцэг эхийн төлөөлөл, сумын Засаг дарга, ИТХ-ын ажлын алба, Ерөнхий боловсролын сургууль, Жаргалан 1 дүгээр цэцэрлэг, Хүслэн 2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Засаг даргын Тамгын газар, сумын Хүүхэд хамгааллын хамтарсан багийн бие бүрэлдэхүүн оролцсон, нийт 270 оролцлоо. Хүүхэд хамгааллын хамтарсан багт 2024 онд 11 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 6 дуудлага, хүүхэд хамгааллын 108 утасны дуудлагын 3 дуудлага ирснийг шуурхай нөхцөл байдалтай танилцан, хариу арга хэмжээг авч ажилласан байна. Эдгээр эрсдэлт гэр бүл, хүүхдэд гэр эргэлт, хяналтыг тавьж, ажиллаж байна. Хамтарсан баг нь 2024 онд 5 удаагийн хурлыг зохион байгуулан, гэр бүлийн хүчирхийлэл эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд хариу арга хэмжээг авах зэрэг ажлыг хэлэлцсэн байна. Сумын хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч буй 96 хүүхдийн эрсдлийн үнэлгээг хийж, www.able.mn праграммд шивж оруулан			
--	--	--	---	--	--	--

			ажилласан байна.Эрсдэлт нөхцөлд амьдарч буй болон хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх арга хэмжээ зохион байгуулж, мэдээллийн санд бүртгэн, хүүхэд, тэдний гэр бүлд чиглэсэн үйлчилгээг зохион байгуулах. “Нэг багш-Нэг хүүхэд” аян Үр дүн: Аяны хүрээнд Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг оношлон судлаж асуудалд тулгуурлан багш бүр эд материал, сэтгэл зүйн дэмжлэг болон хичээлийн хоцрогдолд АУБ багш, мэргэжлийн багш, нийгмийн ажилтантай хамтран ажил үйлчилгээг зохион байгуулж нийт 56 хүүхдэд үзүүллээ. 35 сурагчдад ганцаарчилсан зөвлөгөөг өгч, 84 сурагчийг бүлгийн зөвлөгөө сургалтад давхардсан тоогоор 5 удаа хамруулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүллээ.			
1.7	2023.07.24, Дугаар 03 Төлөвлөгөө батлах тухай	1.Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор ойжуулалт хийх ойн сангийн талбайн хэмжээ газрын нэр, байршлыг 1 дүгээр хавсралтаар, сумын төвийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ газрын нэр, байршлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. 2.Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулж ажиллахыг	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар газар эзэмшүүлэх байршлыг тодорхойлж газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг гарган ажиллаж байна.2023 онд сумын төв суурин газар ногоон байгууламжид-10 га, ойн санд- 20000 га газарт тус тус мод тарьж арчилж ургуулахаар “Номгон простер” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.2024			100

		сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-т даалгасугай.	онд эдгээр газруудад тарьсан бут сөөгийг арчлах ургуулах, хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна.			
1.8	2023.07.24, Дугаар 04 Иргэнд 2024 онд шинээр өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай	1.Сумын 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай. 2.Газар өмчлүүлэх арга хэмжээг холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав), газрын даамал (Ч.Содномцэрэн) нарт үүрэг болгосугай.	2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр 14 иргэнд ... га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хотын хөгжлийн төлөвлөгөө, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй улмаас Засгийн газрын 2024 оны 04 сарын 03 өдрийн 137 дугаар тогтоолоор цуцлагдаж хэрэгжүүлэх боломжгүй болсон.			80
1.9	2023.12.18, Дугаар 06 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай	Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөлтийн хэрэгжилтийг нэгдүгээр, 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай. 1.1.Гэр бүлийн хэрэгцээнд шинээр өмчлүүлэх газрын байршил 1.1.1 14 иргэнд 1,73 га газар Дөрөлж, Хөнжил хороололд, 1.1.2 Гэр бүлийн хэрэгцээнд Дөрөлж, Мааньт, Хөнжил хороололд Усны ай сав газраас хол ямар нэг зөрчилгүй иргэдийн газрыг өмчлүүлэх, 1.1.3 Арал хороололд газар өмчлүүлэхгүй, боломжтой хэсэгт эзэмшлээр олгох, Дөрөлж хороолол, Хөшигт хороололд эгнээ байрлал сайтай газар олгох, 1.2.Эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил	2024 оны 04 сарын 03 өдрийн 137 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн иргэнд 2024 онд шинээр газар өмчлүүлээгүй.Усны сав газрын хамгаалалтын бүс болон Хөшигт хороололд нэмж газар олгоогүй байна. Идэрийн голын гүүрний урд талд 2 нэгж талбар 0,21 га газарт цахим дуудлага худалдаа зарлаж дуулага худалдааны эцсийн үнэ болох 7095000 төгрөгийн орлогыг холбогдох дансанд нь төвөлөрүүлж ажиллалаа. Харилцаа холбооны зориулалтаар А.Хөнжил баг-Той Доод нарийн жалгын			100

		1.2.1.Иргэн, аж ахуй нэгж байгууллагад худалдаа, үйлчилгээний зориулалтаар дуудлага худалдаагаар олгох газрыг “Идэр”-ийн голын гүүрний урд замын уулзварт 2 иргэн, иргэн аж ахуй нэгжид 0,21 га, 1.3.Харилцаа холбооны зориулалтаар ашиглуулах газрын хэмжээ байршил 1.3.1.Иргэн аж ахуйн нэгж байгууллагад Харилцаа холбооны зориулалтаар дуудлага худалдаагаар олгох газрыг, а.Хөнжил баг-Той Доод нарийн жалгын б.Цэцүүх баг-Цагаан уулын хэрвээ 0,04 га, в.Цагаан бургас баг-Чагатагатын хэрвээ 0,09 га, 1.4.Хуучин нэгж талбарын газрын байршил өөрчлөх төлөвлөлт, хэмжээ : 1.4.1 Хөнжлийн аманд 0,5 га, 1.5.Иргэнд өвөлжөө хаваржааны зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын хэмжээ байршил 1.5.1. 1-р баг Хөнжил –Ар тээл 0,48 га, 1.6.Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нөхөн бүрдүүлэлтээр өмчлүүлэх газрын хэмжээ байршил 1.6.1. 5-р баг Мааньт хороололд 3 иргэнд 0,48 газрыг өмчлүүлэхээр тус тус баталсугай.	Б.Цэцүүх баг-Цагаан уулын хэрвээ 0,04 га, в.Цагаан бургас баг-Чагатагатын хэрвээ 0,09 газрыг тус тус ашиглуулахаар төлөвлөж “Мобиком “ компани газрын байршлаа өөрчлүүлэх хүсэлт ирүүлсний уулмаас 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хөнжлийн аманд -0,5 га газрыг байршил өөрчлөх,Өвөлжөө хаваржааны зориулалтаар 1 иргэнд 0,48 га газрыг эзэмшүүлэх төлөвлөлтүүд хэрэгжсэн .			
1.10	2023.12.18, Дугаар 07 Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг шинэчлэн тогтоох, газрын нэгдмэл	1.Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг 1 дүгээр, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэхийг 2 дугаар, газрын нэгдмэл сангийн сумын төвийн тэг гортигийн зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.	Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг 1 дүгээр, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэхийг 2 дугаар, газрын нэгдмэл сангийн сумын төвийн тэг гортигийн зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталж Аймгийн ГХБХБГ-т хүргүүлэн мөрдөж ажиллаж байна.			100

	сангийн ангилал шилжүүлэх тухай	2.Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортиг, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх тухай тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаж ажиллахыг сумын Засаг дарга /Ц.Бямбажав /-д үүрэг болгосугай.			
1.11	2023.12.18, Дугаар 10 2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг батлах тухай	1.Ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагууд болон багийн иргэдийн ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлшний модны дээд хязгаарыг 1 дүгээр, Мөрөн суманд бэлтгэн нийлүүлэх хэрэглээний болон түлээний модны дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. 2.Сумын Засаг дарга (Ц.Бямбажав), Эрчимт-Идэр сум дундын ойн ангийн дарга (Ц.Тайвансайхан), Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Л.Алтанхуяг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Пүрэвсүрэн) нарт ДААЛГАХ нь: 2.1.2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт багтаан Ойн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мод бэлтгэлийн ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллах, 2.2.Ойд арчилгаа цэвэрлэгээний огтлолт (гэрэлжүүлэх. тохируулахаас бусад) явуулсан ойн мэргэжлийн байгууллагуудын бэлтгэсэн 100 м³ мод тутамд 2 га талбайд өөрийн хөрөнгөөр төвлөрүүлсэн байдлаар ойжуулалт хийлгүүлж арчилгаа, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж ажиллах, 2.3.Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ойгоос мод бэлтгэсэн мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээг улирал	Мөрөн суманд бэлтгэн нийлүүлэх модыг Мөрөн сумтай гэрээ байгуулан дүгнэж ажилласан. Мөрөн суманд 420 м3 хэрэглээний мод, 22800 м3 түлээний мод бэлтгэхээр гэрээ байгуулсанаас 32 м3 хэрэглээний мод, 116 м3 түлшний мод бэлтгэн нийлүүлж гэрээ 5,4 хувьтай хэрэгжсэн байна. Энэ нь манай сумаас Мөрөн сум ороход олон даваа давж хол газар тээвэрлэхэд зардал өндөр гардаг нь тус суманд зарагдаж байгаа хэрэглээний болон түлшний модны үнэтэй өрсөлдөж чадахгүй байгаатай холбоотой байна. Сумын хэмжээнд 4640 м3 хэрэглээний мод, 12710 м3 түлшний мод бэлтгэхээс 2345 м3 хэрэглээний мод, 6779 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт хувьтай байна. 8 ойн мэргэжлийн байгууллага 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод бэлтгэхээс 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт 100 хувьтай байна. 53 га талбайг ойжуулхаас 11 га талбайг ойжуулж		90

		бүр дүгнэж. мод модон материалын нийлүүлэлтийг цахимаар сурталчилж мэдээллээр хангаж ажиллах, 2.4.Байгаль хамгаалагчийн олгож буй мод бэлтгэх эрхийн бичгийн бичилт төлбөр хураамж төвлөрүүлэлт, өрхийн ногдол гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, 2.5.Мөрөн сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэглээний болон түлээний модны хэрэгцээг Ойн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 заасны дагуу мөрөн сумын Засаг даргатай гэрээ байгуулж нийлүүлэх арга хэмжээг авч ажиллах, 2.6.Мод бэлтгэлийн доод агуулахаас гарсан мод модон материалын хаягдал (үртэс)-ийг дахин боловсруулах, төвлөрсөн хогийн цэгт хаягүй байх, 2.7.Ойн инженерийг мод бэлтгэлийн үйл ажиллагаанд тогтмол ажиллуулах,	үлдсэн 42 га талбайг ойн ангитай гэрээ байгуулан ирэх оны хавар хийхээр төлөвлөж байна. БОТХБТ-с 2024 онд 1 баг 1 жалга гэсэн бодлого гаргаж бүх мэргэжлийн байгууллагыг 1-р багийн Хөнжилөөс бэлтгүүлсэнээр хяналт сайжирч, мод бэлтгэлийн талбайн хяналт, мод тээвэрлэлтийн хяналт тавихад хялбар болсон. ОМБ-уудын доод агуулхийн модонд 7, 7 хоногоор байгаль хамгаалагч, БОХУлсын байцаагч ээлжээр гарч хяналтын хуудсаар лимитийг хянаж ажиллаж байна. Ингэснээр иргэдийн гар дээрээс мод худалдан авах явдал багассан.			
Хоёр.2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол						
2.1	2024.02.23, Дугаар 01 Сонгуулийн хэсэг байгуулах, нутаг дэвсгэрийг зарлах тухай	1.Сумын байнга оршин суугчдын мэдээллийн санг үндэслэн 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын санал авч тоолох 5 хэсэг байгуулсугай. 2.Хэсгийн дугаар, нутаг дэвсгэрийн байршил, төвийг хавсралтаар баталсугай. 3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох байгууллагад хүргүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.	Сумын ИТХ-ын ээлжит XIV дугаар хуралдаанаар УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу хуулийн хугацаанд сонгуулийн хэсгийг хэсгийн дугаар, нутаг дэвсгэрийн байршилыг харгалзан 5 хэсэг байгуулан, нутаг дэвсгэрийн төвийг тухайн багуудын төвд байхаар тогтоож хурлын тогтоол шийдвэрийг холбогдох дээд байгууллагуудад хугацаанд нь хүргүүлэн Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийг хуулийн			100

			хүрээнд зохион байгуулан ажилласан			
2.2	2024.02.23, Дугаар 02 Зурагт самбар байршуулах байршлыг тогтоож, нийтэд мэдээлэх тухай	1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байршуулах нэгдсэн самбарыг сумын орон нутгийн судлах музейн урд, сургуулийн түлээний хашааны хажуу талд тус тус 1 ширхэг сурталчилгааны зурагт самбарыг Хаан банкны урд үзүүрээс мал эмнэлгийн хашааны урд үзүүр, мал эмнэлгийн хашааны урд үзүүрээс мал эмнэлгийн хашааны урд үзүүр, мал эмнэлгийн хашааны урд үзүүрээс Төрийн банк, Төрийн банкны урд үзүүрээс Ерөнхий боловсролын сургуулийн зүүн урд үзүүр, Ерөнхий боловсролын зүүн урд үзүүрээс, Ерөнхий боловсролын сургуулийн баруун урд үзүүр, Ерөнхий боловсролын баруун урд үзүүрээс НИК шатахуун түгээн станц, НИК шатахуун түгээх станцаас заводны хашааны баруун урд үзүүр, заводны хашааны баруун урд үзүүрээс Хаан банк, Хаан банкнаас Соёл спортын цогцолбор хүртэл байхаар тогтоож иргэдэд мэдээлсүгэй. 2.Нэгдсэн самбарыг Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж байрлуулахыг сумын Засаг дарга /Ц.Бямбажав/-т даалгасугай.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заагдсан хугацаанд нэр дэвшигчийн сурталчилагааны зурагт хуудсыг байрлуулах нэгдсэн самбарыг хуулийн хугацаанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон байршилд байршуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа. Нийт 86 нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулах сурталчилгааны 2 нэгдсэн самбар байршуулан ажиллаж тогтоолын хэрэгжилт 100 хувьтай. 			100
2.3	2024.04.29 Дугаар 02 Төлөөлөгчийн үнэмлэх, хэвлэмэл хуудас, тэмдэг	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үнэмлэх, хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх журмыг хавсралтаар баталсугай. 2.Үнэмлэх, хэвлэмэл хуудас, тэмдгийг журмын дагуу ашиглахыг сумын иргэдийн	Сумын ИТХ-ын төлөөлөгчийн үнэмлэх, хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.			100

	хэрэглэх журам батлах тухай	Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд үүрэг болгосугай. 3.Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бат-Эрдэнэ)- д үүрэг болгосугай.				
2.4	2024.04.29 Дугаар 03 Агнуурын бүс нутаг тогтоох тухай	1.Ахуйн зориулалтын агнуурын бүс нутгийн байршил, хилийн цэс, талбай хэмжээг нэгдүгээр, тусгай зориулалтын “Тосонгийн зоо” агнуурын бүс нутгийн байршил, хилийн цэс, талбай хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2.“Агнуурийн менежментийн тэх төв” төрийн бус байгууллагын боловсруулсан 2022-2027 онд хэрэгжүүлэх агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө, “Агнуур судлалын нийгэмлэг” төрийн бус байгууллагын боловсруулсан 2024-2029 онд хэрэгжүүлэх “Тосонгийн зоо” агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус дэмжсүгэй. 3.Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай хамтран, агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан тус сумын хэмжээнд ан амьтныг хамгаалах, агнуурын нөөцийг зохистой ашиглах бодлого боловсруулан, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-д үүрэг болгосугай.	Агнуурийн менежментийн тэх төв” төрийн бус байгууллагын боловсруулсан 2022-2027 онд хэрэгжүүлэх агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө, “Агнуур судлалын нийгэмлэг” төрийн бус байгууллагын боловсруулсан 2024- 2029 онд хэрэгжүүлэх “Тосонгийн зоо” агнуурын бүс нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө хийлгэж сумын ИТХ-аар оруулан батлуулсан. Агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай хамтран, агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан тус сумын хэмжээнд ан амьтныг хамгаалах, агнуурын нөөцийг зохистой ашиглах бодлого боловсруулан, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан. Энэ онд тусгай зориулалтаар 2 буга агнуулж орон нутгийн орлогод 15 сая төгрөг тушаасан байна.			100

2.5	2024.05.29 Дугаар 01 Малын тоо толгойн албан татварыг тэглэх тухай	1.Тус сумын хэмжээнд 2024 оны 1 толгой малд ногдох малын тоо толгойн албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай. 1.1 Адуу 0 төгрөг 1.2 Үхэр 0 төгрөг 1.3 Тэмээ 0 төгрөг 1.4 Хонь 0 төгрөг 1.5 Ямаа 0 төгрөг 2.Уг шийдвэр гарсантай холбогдуулан өмнөх онуудын малын тоо толгойн албан татвараа төлөөгүй айл өрхүүдээр бүрэн төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав), татварын улсын байцаагч (С.Ганзул) нарт үүрэг болгосугай.	2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 онд ногдох Малын тоо толгойн албан татварыг 0 төгрөгөөр тогтоосон тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6842 дугаарт бүртгэснийг ажилдаа хэрэгжүүлж ажиллаж байна. Урд оны Малын тоо толгойн албан татварын өр 22000,0 мянган төгрөгөөс 11 дүгээр сарын 30 ны байдлаар 11433,2 мянган төгрөгийг барагдуулаад байна.			100
2.6	2024.06.27 Дугаар 01 2024 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт өөрчлөлт оруулах тухай	1.Ойн нөхөрлөл, багийн иргэдийн ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлшний модны дээд хязгаарыг хавсралтаар баталсугай. 2.Сумын Засаг дарга (Ц.Бямбажав), Эрчимт-Идэр сум дундын ойн ангийн дарга (Ц.Тайвансайхан), Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Л.Алтанхуяг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Пүрэвсүрэн) нарт ДААЛГАХ нь: 2.1.2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт багтаан Ойн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мод бэлтгэлийн ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг, 2.2.Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ойгоос мод бэлтгэсэн ойн нөхөрлөлүүдтэй	Сумын хэмжээнд 4640 м3 хэрэглээний мод, 12710 м3 түлшний мод бэлтгэхээс 2345 м3 хэрэглээний мод, 6779 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт хувьтай байна. 8 ойн мэргэжлийн байгууллага 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод бэлтгэхээс 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт 100 хувьтай байна. 53 га талбайг ойжуулхаас 11 га талбайг ойжуулж үлдсэн 42 га талбайг ойн ангитай гэрээ байгуулан ирэх оны хавар хийхээр төлөвлөж байна.			100

		байгуулсан гэрээг улирал бүр дүгнэж ажиллахыг, 2.3.Байгаль хамгаалагчийн олгож буй мод бэлтгэх эрхийн бичгийн бичилт төлбөр хураамж төвлөрүүлэлт, өрхийн ногдол гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг,	БОТХБТ-с 2024 онд 1 баг 1 жалга гэсэн бодлого гаргаж бүх мэргэжлийн байгууллагыг 1-р багийн Хөнжилөөс бэлтгүүлсэнээр хяналт сайжирч, мод бэлтгэлийн талбайн хяналт, мод тээвэрлэлтийн хяналт тавихад хялбар болсон. ОМБ-уудын доод агуулхийн модонд 7, 7 хоногоор байгаль хамгаалагч, БОХУлсын байцаагч ээлжээр гарч хяналтын хуудсаар лимитийг хянаж ажиллаж байна. Ингэснээр иргэдийн гар дээрээс мод худалдан авах явдал багассан.			
2.7	2024.06.27 Дугаар 03 Хяналтын зөвлөл өөрчлөн байгуулах тухай	1.Хоршоог хөгжүүлэх сангийн зарцуулалт, олгосон зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай. 2.Хяналтын зөвлөлийн дарга (Э.Бат-Эрдэнэ), нарийн бичгийн дарга (Г.Даваажаргал), зөвлөлийн гишүүдэд ДААЛГАХ нь: 2.1.Хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэхь заалтыг хэрэгжүүлж ажиллах, 2.2.Хоршоог хөгжүүлэх санаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журманд заагдсан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэн нээлттэй ил тод ажиллах,	2024 оны 01 сарын байдлаар 2011-2019 оны хугацаа хэтэрсэн 35 зээлдэгчийн 81,351,779 төгрөг, 2022-2023 оны 22 зээлдэгчийн 209,459,280 төгрөг, нийт 57 зээлдэгчийн 291,692,486 авлагатай байсан. Төслийн хэрэгжилт эргэн төлөлтөд байнгын хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлдэгч нартай зээлийн эргэн төлөлтийг барагдуулах талаар сар болгон утсаар ярьж, албан мэдэгдэл өгч ажиллаж байна. 2024 оны 01 сараас хойш хугацаа хэтэрсэн зээлдэгч Д.Амартөр, М.Оюундалай, Ж.Халтар, Г.Гомбосүрэн, Д.Гомбоцэрэн, Н.Гал Идэр, Б.Амаржаргал, Б.Энхбаатар, Д.Түмэндэмбэрэл,			100%

		3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 03 дугаартай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.	Ж.Энхбат, Ч.Өлзийтогтох, Ш.Ганжамъян, Б.Сандагдорж, С.Батжаргал, Л.Батмөнх гэсэн 15 зээлдэгчийг 29,776,138 төгрөг, сар болгон эргэн төлөлт хийж буй хугацаа хэтэрсэн иргэдийн 7,500,000 төгрөг нийт 37,276,138 төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлж ажиллаа. 12 сарын байдлаар нийт 42 зээлдэгчийн 192,577,149 төгрөгийн авлагатай байна. 2023 оны А/521 дүгээр тушаалын хавсралт “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх, хяналт тавих журмын – ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь хэсэгт зааснаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 17 дугаар хуралдаанаар хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2024 оны 09 дугаар сарын 30 ны өдөр зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн гэж үзсэний үндсэн дээр төсөл сонгон шалгаруулахаар товыг тогтоолгосон. 2.11-т Төсөл хүлээн авах хугацааг тухайн сумын иргэдэд мэдэгдсэнээс хойш 30 хоногийн хугацаанд цахимаар эсвэл цаасан хэлбэрээр хүлээн авсан гэсэн			
--	--	---	--	--	--	--

			журмын дагуу төсөл хүлээн авах хугацаанд төсөл ирүүлсэн хоршоо байхгүй. Журмын дагуу 2025 онд зарлах төлөвлөгөөтэй ажиллаж байна.			
2.8	2024.06.27 Дугаар 04 Баяр наадмын тов тогтоох тухай	1.Ардын хувьсгалын 103 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр товлосугай. 2.Үндэсний их баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх саналыг аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д уламжилсугай. 3.Ардын хувьсгалын 103 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг ханган зохион байгуулах арга хэмжээг авч нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-т даалгасугай.	Үндэсний Их баяр наадмыг ИТХ-ын тогтоолоор товолсон хугацаанд тэмдэглэн өнгөрүүлсэн			100
2.9	2024.08.08 Дугаар 01 Нэр дэвшигчийн ухуулах хуудас болон зурагт самбарыг байрлуулах байршлыг тогтоох тухай	1.Сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас болон зурагт самбарыг байрлуулах байршлыг хавсралтаар баталсугай. 2.Ухуулах хуудас болон зурагт самбарыг байрлуулахдаа тогтоосон гудамж талбай, олон нийтийн газарт байрлуулан аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 40, 41 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн мөрдлөг болгож ажиллахыг сонгуульд нэр дэвшүүлэх нам, эвслийн хороодын дарга нарт даалгасугай.	Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигчдийн сурталчилгааны ухуулах хуудас, зурагт самбарыг ИТХ-ын тогтоолоор тогтоосон байршилд байршуулан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сонгуулийн хорооноос 100 хангуулан ажилласан.			100
2.10	2024.08.08 Дугаар 02	1.Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Данигайн Даваанямын нэрэмжит Жаргалант сумын Соёлын төвийн түүхт 80 жилийн ойг 2024 оны 10 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх саналыг дэмжсүгэй.	Соёлын төвийн үүсэн байгуулагдсан түүхт 100 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 10			100

	Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай	2.Жаргалант сумын Соёлын төвийн түүхт 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлж өгөхийг аймгийн Соёл урлагийн газрын дарга (Л.Батцэцэг)-д уламжилсугай. 3.Соёлын төвийн түүхт 80 жилийн ойг ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд зохион байгуулж, ойн арга хэмжээ, хандив зарцуулалтын тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг ой зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч (Ж.Баттүшиг), Соё спорт цогцолборын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Шажинбат) нарт үүрэг болгосугай.	дугаар сарын 01-02 ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн. Ойгоор цугларсан хандивын зарцуулалт тайланг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025 оны ажлын төлөвлөнд тусгуулан ажиллаж байна.			
2.11	2024.08.08 Дугаар 03	1.Ойн мэргэжлийн байгууллагууд болон багийн иргэдийн ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлшний модны дээд хязгаарыг баталсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит XII хуралдааны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад хуваарилан заагдсан тоо хэмжээг нэмэгдүүлсэнийг хавсралтаар баталсугай. 2.Сумын Засаг дарга (Ц.Бямбажав), Эрчимт-Идэр сум дундын ойн ангийн дарга (Ц.Тайвансайхан), Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Л.Алтанхуяг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Пүрэвсүрэн) нарт ДААЛГАХ нь: 2.1.2024 онд нэмэлтээр батлагдсан ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт багтаан Ойн	Сумын хэмжээнд 4640 м3 хэрэглээний мод, 12710 м3 түлшний мод бэлтгэхээс 2345 м3 хэрэглээний мод, 6779 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт хувьтай байна. 8 ойн мэргэжлийн байгууллага 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод бэлтгэхээс 1710 м3 хэрэглээний мод, 1600 м3 түлшний мод тус тус бэлтгэж биелэлт 100 хувьтай байна. 53 га талбайг ойжуулхаас 11 га талбайг ойжуулж үлдсэн 42 га талбайг ойн ангитай гэрээ байгуулан ирэх оны хавар хийхээр төлөвлөж байна.			100

	2024 оны ойгоос бэлтгэх модны хэмжээг нэмж батлах тухай	тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мод бэлтгэлийн ажлыг зохион байгуулан хяналт тавьж ажиллах, 2.2.Ойд үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн ойн мэргэжлийн байгууллагуудын бэлтгэсэн 100 м³ мод тутамд 2 га талбайд , арчилгаа цэвэрлэгээний огтлолт (гэрэлжүүлэх. тохируулахаас бусад) явуулсан ойн мэргэжлийн байгууллагуудын бэлтгэсэн 100 м³ мод тутамд 1 га талбайд, иргэдийн уламжлалт бүтээгдхүүн үйлдвэрлэх зорилгоор ойгоос ургаа нойтон мод бэлтгэсэн иргэний огтолсон 1 ширхэг мод тутамд 20 ширхэг тарьц тариулах арга хэмжээг тус тус өөрийн хөрөнгөөр төвлөрүүлсэн байдлаар ойжуулалт хийлгүүлж арчилгаа, хамгаалалтын асуудлыг шийдвэрлүүлэх, 2.3.Мод бэлтгэлийн талбай тусгаарлах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ойгоос мод бэлтгэсэн иргэн, мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээг улирал бүр дүгнэж, мод модон материалын нийлүүлэлтийг цахимаар сурталчилж мэдээллээр хангаж ажиллах, 2.4.Байгаль хамгаалагчийн олгож буй мод бэлтгэх эрхийн бичгийн бичилт төлбөр хураамж төвлөрүүлэлт, өрхийн ногдол гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, 2.5. Мод бэлтгэлийн агуулахаас гарсан мод модон материалын хаягдал (үртэс)-ыг дахин боловсруулах, төвлөрсөн	БОТХБТасгаас 2024 онд 1 баг 1 жалга гэсэн бодлого гаргаж бүх мэргэжлийн байгууллагыг 1-р багийн Хөнжилөөс бэлтгүүлсэнээр хяналт сайжирч, мод бэлтгэлийн талбайн хяналт, мод тээвэрлэлтийн хяналт тавихад хялбар болсон. ОМБ-уудын доод агуулхийн модонд 7, 7 хоногоор байгаль хамгаалагч, БОХУлсын байцаагч ээлжээр гарч хяналтын хуудсаар лимитийг хянаж ажиллаж байна. Ингэснээр иргэдийн гар дээрээс мод худалдан авах явдал багассан.			
--	--	--	--	--	--	--

		хогийн цэгт хаягүй байх, 2.6.Ойн инженерийг мод бэлтгэлийн үйл ажиллагаанд тогтмол ажиллуулах,				
2.12	2024.08.08 Дугаар 04 Ойн нөхөрлөл байгуулах тухай	1.1 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлаас дэмжигдсэн Орой халзан ойн нөхөрлөлийг байгуулсугай. 2.Оройн халзан ойн нөхөрлөлтэй Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу ойн санг эзэмшүүлэх гэрээ багуулан гэрчилгээжүүлж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-т үүрэг болгосугай. 3.Ойн нөхөрлөл нь гэрээгээр эзэмшсэн ойн сангаа хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, эзэмшсэн ойн сандаа ой зохион байгуулалт хийлгэх, ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлт үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг ойн нөхөрлөлийн ахлагчид үүрэг болгосугай. 4.Ойн нөхөрлөлийн гишүүдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол явуулж гарын авлага материал, заавар зөвлөмжөөр ханган нягт уялдаа холбоотой хамтран ажиллахыг Эрчимт-Идэр сум дундын ойн ангийн дарга (Ц.Тайвансайхан), сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогийн тасгийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Пүрэвсүрэн), байгаль хамгаалагч (Б.Батчулуун) нарт үүрэг болгосугай.	1 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлаас дэмжигдсэн Орой халзан ойн нөхөрлөлийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Оройн халзан ойн нөхөрлөлтэй Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу ойн санг эзэмшүүлэх гэрээ багуулан гэрчилгээжүүлж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллав. Ойн нөхөрлөл нь гэрээгээр эзэмшсэн ойн сангаа хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, эзэмшсэн ойн сандаа ой зохион байгуулалт хийлгэх, ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлт үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллаж байна. Сумын БОТХБТасаг, Эрчимт идэр СДОАнгитай хамтран ойн нөхөрлөлийн гишүүдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол явуулж гарын авлага материал, заавар зөвлөмжөөр ханган нягт уялдаа холбоотой хамтран ажилласан.			100

2.13	2024.09.26 Дугаар 01 Сумын 2024 оны төсөвт тодотгол хийх тухай	1. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII хуралдаанаар аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан сумын 2024 оны төсвийн тодотголыг төсвийн жилд дор дурдсанаар баталсугай. 2.Сумын 2024 оны төсвийн эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай. 3. Сумын 2024 оны төсвийн жилд төсвийн захирагч нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай. 4.Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад олгох орон нутгийн санхүүжилтийн хэмжээг дор дурдсанаар баталсугай. 5.Улсын Их Хурлаас баталсан төсөвтэй холбогдуулан сумын 2024 оны төсвийн тодотголоор төсвийн санхүүжих эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай: 5.1.Суманд олгогдох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 1,080,057.7 мянган төгрөг, 5.2.Сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 774,807.5 мянган төгрөг 5.3.Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 271,887.5 мянган төгрөг, ХХС-ийн үлдэгдлээс зээл олгоход 12,614.2 мянган төгрөг, 5.4.Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 796,116.0 мянган төгрөгөөр тус тус баталсугай. 6.Сумын ерөнхий орлогын дансны 2023 оны жилийн эцсийн дансны үлдэгдэл 43,550.0 мянган төгрөг, давсан орлогын 83,180.0 мянган	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII хуралдаанаар аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан сумын 2024 оны төсвийн тодотголыг 09 сарын 26-ны 01 дугаар тогтоолоор баталсан.Энэхүү тогтоолоор орон нутгийн орлогын давж биелсэн дүнгээр аймгаас өгдөг санхүү дэмжлэгийг бууруулж төсвийн тодотголыг хийсэн. Сумын ИТХ-аар малын тоо толгойн албан татврыг 00 үнэлгээгээр тогтоосон тул энэ тогтоолоор Малын тоо толгойн албан татврын орлогыг хасах тодотгол хийж баталсан.Орон нутгийн орлогыг 774,807.5 мян.төгрөгөөр ,Санхүү дэмжлэгийг 1,080,057.7 мян.төгрөгөөр ОНХС-ийн орлогын үйлжүүлгийг 271,887.5 мян.төгрөгөөр ,давсан орлогыг 186,231.9 мян.төгрөгөөр,дансны үлдэгдлээс санхүүжих орлогыг 204,347.5 мян.төгрөгөөр ,өөрийн орлогоос буюу ХХСангийн зээлдэгчийн зээлийн орлогыг 117,800.0 мян.төгрөгөөр ,ЭИСДОА-ийн өөрийн орлогыг 10,000.0 мян.төгрөгөөр нийт 2,645,132.1 мян. төгрөгөөр төсөв захиаргч нарт зарцуулах эрхийг хуваарийн дагуу бүрэн олгосон.Тайланд онд шинээр өр авлага үүсээгүй болно. Энэ онд 11 дүгээр сарын 31-ны байдлаар			100
------	--	---	--	--	--	-----

		төгрөгийг тогтоолын нэгдүгээр хавсралтад заасны дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн тодотголоор хасагдсан 40,000.0 мянган төгрөгийг тогтоолын хоёрдугаар хавсралтад заасны дагуу зарцуулсугай. 7.Төсвийн тухай хуульд заасан зарчмын дагуу төсвийг зохистой удирдаж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, үүссэн өр авлагыг барагдуулах, шинээр өр авлага үүсгэхгүй байх, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг нийт төсөв захирагч нарт даалгасугай. 8.Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс хуваарилагдсан төсвийг хууль журамд тусгагдсан зориулалтын дагуу хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт арга хэмжээнд зарцуулахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажавт) -д үүрэг болгосугай.	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 94,097.3 мян.төгрөг төлөгдсөн байна.ОНХС-ийн орлогын шилжүүлэгээс 15-н төсөл ажил хэрэгжүүлэхээс төсвийн тодотголоор 4 ажил нэмж төлөвлөсөнөөс огт хэрэгжээгүй 2 зам засврын ажил шилжих хөрөнгө оруулалтаар дараа онд хийж гүйцэтгэнэ. Бусад хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж Сангийн сайдын 86-р тушаалын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлж ажилласан .Төсвийн тухай хуулийн дагуу тайлант онд өр авалагагүй ажиллаж байна.			
2.14	2024.09.26 Дугаар 02 Төсөл сонгон шалгаруулах хороог өөрчлөн байгуулах тухай	2.1.Хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэхь заалтыг хэрэгжүүлж ажиллах, 2.2.Хоршоог хөгжүүлэх санаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журманд заагдсан тавигдах шаардлагуудыг хангасан төслүүдийг хүлээж авч, шударга, нээлттэй ил тод зарчмыг баримтлан шалгаруулах, 2.3.Сангаас олгох зээлийн хэмжээг нэг хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх хоршоонд 10.000.000-20.000.000 төгрөг (арван саяаас хорин сая) -ийг олгох зарчмыг баримтлах,	2023 оны А/521 дүгээр тушаалын хавсралт “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх, хяналт тавих журмын –ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь хэсэгт зааснаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 17 дугаар хуралдаанаар хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2024 оны 09 дугаар сарын 30 ны өдөр зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн гэж үзсэний үндсэн дээр төсөл сонгон			100%

		3.Сангийн үйл ажиллагааны талаарх журамд заагдсан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-т үүрэг болгосугай.	шалгаруулахаар товыг тогтоолгосон. Суманд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хоршоонуудад мэдээлэл хүргэж, мөн сумын Засаг тамгын газрын групп, сумын сайтад сангаас зээл авч хэрэгжүүлэх хоршооны шаардлага, төсөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын талаар зар, мэдээ мэдээлэл хүргэж ажилласан.			
2.15	2024.09.26 Дугаар 03 Төсөл сонгон шалгаруулах тов тогтоох тухай	1.Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр сонгон шалгаруулахаар тогтоосугай.	2.11-т Төсөл хүлээн авах хугацааг тухайн сумын иргэдэд мэдэгдсэнээс хойш 30 хоногийн хугацаанд цахимаар эсвэл цаасан хэлбэрээр хүлээн авсан гэсэн журмын дагуу төсөл хүлээн авах хугацаанд төсөл ирүүлсэн хоршоо байхгүй. Журмын дагуу 2025 онд зарлах төлөвлөгөөтэй ажиллаж байна			100%
2.16	2024.10.30 Дугаар 01 Төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит 9 дэх удаагийн сонгуульд хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчдийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцон нэр бүхий 25 төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, нэрсийг хавсралтаар баталсугай. 2.Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгчдөд	Сумын сонгуулийн хорооны тогтоолын дагуу сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 25 хамгийн олон санал авсан 25 төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч ИТХ-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.			100

		иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн энгэрийн тэмдэг, үнэмлэхийг олгосугай. 3.Хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдөж, хурлын төлөөлөгчийн үүрэг, хариуцлага, ёс зүйг эрхэмлэн төлөөллийн эрх үүргээ хэрэгжүүлэн, сум орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлж, иргэдийнхээ нийтлэг эрх ашигт тулгуурлан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хурлын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, өөрийгөө хөгжүүлэн Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд үр дүнтэй, идэвх санаачлагатай ажиллахыг шинээр сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (Төлөөлөгчид)-д үүрэг болгосугай.	ИТХ-ын 25 төлөөлөгчөөс 17 эрэгтэй, 8 эмэгтэй төлөөлөгч сонгогдсон байна.			
2.17	2024.10.30 Дугаар 02 Хуралдааны дэг батлах тухай	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай. 2.Хуралдааны дэгийг мөрдлөг болгон биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Төлөөлөгч нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар ИТХ-ын хуралдааны дэгийг шинэчилэн баталж хурлын хуралдааныг дэгийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.			100
2.18	2024.10.30 Дугаар 03 Ажлын хэсэг байгуулах тухай	1.Хуралдаанаар хэлэлцэж буй асуудлаар санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Дарга: Б.Мягмаржаргал (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Гишүүд: Ч.Баяржаргал (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Ө.Бадамдорж (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Т.Цэвэлмаа (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Б.Пүрэвсүрэн (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)	Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан тооллогын комисс байгуулан / ажлын хэсэг/ тооллогын комисс санал хураалтыг дүнг нэгтгэн танилцуулж баталгаажуулан ажилласан байна.			100

		2.Хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулж, хуралдааны дэг, дотоод журмын дагуу шударгаар зохион байгуулж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанд танилцууллахыг ажлын хэсгийн дарга (Б.Мягмаржаргал)-д даалгасугай.				
2.19	2024.10.30 Дугаар 04 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас чөлөөлөх тухай	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үр дүнгээс хамааруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Бираагийн Ахмадбатыг 2024 оны 10 дугаар сарын 30 -ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй. 2.Б.Ахмадбат-д албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгохыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бат-Эрдэнэ), нягтлан бодогч (Э.Содбилэг) нарт зөвшөөрсүгэй.	Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар сумын ИТХ-ын даргаар 2020-2024 онд ажилласан Бираагийн Ахмадбатыг үүрэгт ажлаас чөлөөлөн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 заасны дагуу 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг 2025 оны төсөвт тусган олгуулахаар ажиллаж байна.			80
2.20	2024.10.30 Дугаар 05 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгож батлах тухай	1.Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс хамгийн олон буюу 52 хувийн санал авсан Лундаажанцангийн Алтанхуягийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгож, баталсугай. 2.Хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдөж, хурлын даргын үүрэг, хариуцлага, ёс зүйг эрхэмлэн төлөөллийн байгууллагын удирдах эрх үүргээ хэрэгжүүлэн, сум орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлж, иргэдийнхээ нийтлэг эрх ашигт тулгуурлан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд үр	Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар сумын ИТХ-ын даргаар Лундаажанцангийн Алтанхуягыг олонхийн саналаар сонгон ИТХ-ын даргаар ажиллаж байна.			100

		дүнтэй, идэвх санаачлагатай, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.				
2.21	2024.10.30 Дугаар 06 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл байгуулж, тоог тогтоох тухай	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдийн тоог 7 байхаар тогтоосугай. 2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож баталсугай. Үүнд: Дарга: Л.Алтанхуяг - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга) Гишүүдэд: Б.Цэрэндорж - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) С.Бат-Өлзий - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Т.Цэвэлмаа - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Н.Даваадулам - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Н.Эрдэнэбат - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) Б.Сайнбат - (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч) 3.Зөвлөлийн ажиллах журмын дагуу чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Зөвлөлийн дарга (Л.Алтанхуяг)-д даалгасугай.	2024 онд Зөвлөлийн хуралдааныг 5 удаа хуралдуулж хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг Зөвлөлийн хуралдаанаар урьдчилан хэлэлцэн ажиллассан. зөвлөлийн хуралдааны дундаж ирц 87,5 хувийн ирцтэй хуралдсан байна. 2024 оны Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын анхдугаар хуралдаанаар Зөвлөлийн гишүүдийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж 2 удаа 100 хувийн ирцтэй хуралдсан. Зөвлөл нь сумын ИТХ-ын өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг ханган, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад оролцож байна.			100
	2024.10.30	1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хороодыг 5 байхаар тогтоосугай. а.Нутгийн удирдлага, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангах асуудал хариуцсан хороо,	Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн 07 дугаар тогтоолоор ИТХ-ын дэргэдэх хороодыг байгуулж, бүрэлдэхүүнийг томилон			80

2.22	<i>Дугаар 07</i> Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай	б.Төсөв санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хяналтын асуудал хариуцсан хороо, в.Нийгмийн бодлого, боловсрол, соёл спорт, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал хөгжлийн асуудал хариуцсан хороо, г.Байгаль орчин, аялал жуулчлал, дэд бүтэц, хөдөө аж ахуй хөгжлийн хороо, д.Төлөөлөгчийн манлайлал, ёс зүйн асуудал хариуцсан хороо, 2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай. 3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит III хуралдааны 06 дугаар тогтоолоор батлагдсан Хороодын ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодод үүрэг болгосугай	2021 оны 01 дүгээр сарын 29 ны өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолоор Хороодын ажиллах журмыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх хороодын үйл ажиллагааг сайжруулах, идэвхжүүлэх, хороодын гишүүдийн чадвахжуулах, сургалт, мэдээ мэдээллээр хангахад анхаарч МНУХолбооны ажиллаа. 2025 оны төсөвт хороодын ажиллах зардалд 2 сая төгрөгийг орон нутгийн давсан орлогоос шийдвэрлэх, ажиллах нөхцөл боломжоор ханган ажлын албанаас зөвлөн тусалж хамтран ажиллаа. ИТХ-ын дэргэдэх хороодын 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хурлын даргаар батлуулан хэрэгжилтийг 100 ханган ажиллахаар төлөвлөөд байна.			
2.23	<i>2024.10.30</i> <i>Дугаар 08</i> Сумын Засаг даргад нэр дэвшүүлэх тухай	1.Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс хамгийн олон буюу 52 хувийн санал авсан Дашцэдэнгийн Амарбаясгаланг сумын Засаг даргад нэр дэвшүүлж аймгийн Засаг даргад уламжилсугай.	Орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан сумын ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар Ардчилсан намаас сумын Засаг даргад нэр дэвшүүлсэн аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Д.Амарбаясгаланг анхдугаар хуралдаангд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн			100

			нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу холбогдох материалыг аймгийн Засаг даргад хүргүүлэн аймгийн Засаг даргын 2024 оны тоот захирмжаар сумын Засаг даргаар томилогдон ажиллаж байна.			
Дундаж хувь						93.2

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2024 онд хэрэгжих 34 тогтоолын биелэлтийн хувь: 93.2

1. 100 хувийн биелэлттэй 26,
2. 90 хувийн биелэлттэй 2,
3. 80 хувийн биелэлттэй 4,
4. 70 хувийн биелэлттэй 2,

ХЯНАСАН: ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.БАТ-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН